



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 1/72

Хархорин сум

**Цэрэг татлагын ажил зохион
байгуулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, Монгол улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Цэрэг татлагын ажлыг 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулсугай.

2.Цэрэг татлагын ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, ажил үүргийн хуваарийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Цэргийн 18-25 насны залуучуудыг цэрэг татлагад бүрэн хамруулж, бэлтгэл ажил хангахыг багийн Засаг дарга нарт даалгасугай.

4.Цэрэг татлагын ажил зохион байгуулахад шаардагдах санхүүжилтийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Лхагвадулам), гүйцэтгэлээр тайлагнахыг нягтлан бодогч (О.Гангаацэрэн)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.БАТ-ЭРДЭНЭ

